



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ХОВД-ИЙН 6-Р БАГЦЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ховд 2024.04.24

Сурагчийн ширээ сандал-47,520,000 төгрөг

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг	Зураг
1	6 настны Сурагч сандал	<p>"Сурагчийн ширээ, сандал техникийн шаардлага" MNS 6582:2016 стандартыг баримтлана. Ширээний тавцанг ISO 9001:2008 чанарын менежментийн системийн стандартыг хангасан, E1 стандартын хүний эрүүл мэндэд хоргүй дотор хэрэглээнд ашиглах зориулалттай, шахмал хавтан, нягт нь 600кг/м3 багагүй, орцын 60-90% нь цэвэр модны үртэсээс бүрдсэн, гэр ажуй хүүхдийн тавилга үйлдвэрлэх зориулалттай меламина хуулгатай 18мм зузаантай үртсэн хавтан (ДСГ, МДФ, HDF) ашиглан үйлдвэрлэсэн. Гоёлын меламина хуулга буюу өнгөлгөө нь ус чийг нэвтрүүлдэггүй, эдэлгээний явцад зураас үүсдэггүй өндөр чанар бүхий хавтангаар хийсэн байна. Ширээний тавцанг 12 мм-ийн диаметртэй 16 ширхэг 3-ын холбоосоор холбож бэхэлсэн. Ширээний тавцанд үзэг хийх зориулалттай ховил ухаж суулган эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, харшил үүсгэгч бодис агуулагдаагүй будгаар будсан байна. Булангууд нь 30мм дугуй. Ширээний булан хөвөөг нь стандартын шаардлага хангасан өнгө дагуу 1.2мм зузаантай PVC материалаар хамгаалсан. Ширээний ирмэг хуулга нь ISO 9001:2008 чанарын менежментийн системийн стандарт хангасан, ISO 14001 байгальд ээлтэй менежментийн системийн стандарт хангасан. 1.2мм зузаантай поливинил хлорид (polyvinyl chloride, PVC) хуулгатай байна. Ширээний тулгуур хөлийн төмрийг 2.5-3см х 5-6см хэмжээтэй 1.5-2мм зузаантай циллиндэр хэлбэртэй төмрөөр хийсэн. Ширээний хөлийг төмрийн зориулалтын будгаар шүршиж будсан. Энэхүү будаг нь эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, харшил үүсгэгч бодис агуулагдаагүй байх. Тавцан шаргал ширээний хөл цагаан саарал өнгөтэй байна. Хөлийн хуванцар материалан хамгаалагчийн зузаан нь 2мм, шалтай харьцах доод ёроол хэсэг нь 4мм-ийн зузаатай резин хуванцарын нэгдэл бөгөөд энэ нь шал урахгүй зураас гаргахгүй, хагарахгүй давуу талтай. Хөлийн хамгаалагч нь зөвөөрлөх үед унахгүй бат бөх бэхлэгдсэн байна.Ширээ нь тогтвортой бат бөх байна. Ширээний өндөр намыг тохируулах боломжтой байна. /Тохируулгын хоорондын Техникийн шаардлагад бүрэн нийцсэн хэмжээ 80-160мм, тохируулгын нүхний тоо 3-5, тохируулгын нүхний хэмжээ 10мм/ ширээг өндөр нам болгох тогтоогч нь салгаж буцааж эргүүлж хийдэг 2 ширхэг боолттой бөгөөд хөлийн залгаацыг хуванцараар хамгаалсан бөгөөд найдвартай түгжигддэг байна. Сурагчийн ширээ нь тавиургүй 2 талд өлгүүртэй байна. Ширээний хэмжээ: L600мм х W500мм х H580мм.</p>	72	
2	6 настны ширээ, сандал	<p>"Сурагчийн ширээ, сандал техникийн шаардлага" MNS 6582:2016 стандартыг баримтлана.Сандлын суудал болон аравч нь E1 терлийн хүний биед нөлөөгүй дотор хэрэглээнд зориулсан 9мм зузаантай, 6- 8%-ийн чийгшилтэй шилмүүст панеран хавтанг, хүүхэд суухад тухтай байдлаар матаж үйлдвэрлэсэн. Гоёлын меламина өнгөлгөөтэй хавтан.Тавцан түшлэг,хөлийг боолтоор холбож өгнө. Боолтны толгой тавцан болон түшлэгийн гадаргуутай нэг түвшинд, боолтны толгойд хамгаалалт хийгдсэн байна. Суудал болон түшлэг хэсэгт булангууд нь 30мм дугуй. Суудлын урд ирмэг хэсэг 50мм налууутай хурц ирмэггүй. Суудал болон түшлэгийн хөвөөг тунгалаг лакаар 3 үе тунгалаг лак нь панеран хавтанг салахаас хамгаалах төдийгүй, хүүхдийн хөл хувцасыг урахаас бүрэн хамгаалдаг. Сандлын хөл нь төмрөөр хийгдсэн. Сандлын тавцан хотгор, шаргал өнгөтэй. Ширээний хөлийн тулгуур төмрийг 2.5-3см х 5-6см хэмжээтэй 1.5-2мм зузаантай циллиндэр хэлбэртэй төмрөөр хийсэн. Сандлын хөлийг төмрийн зориулалтын будгаар шүршиж будсан. Энэхүү будгийн хар тугалганы орц нь ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд байдаг тул эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, харшил үүсгэгч бодис агуулагдаагүй байх. Сандлын хөл цагаан саарал өнгөтэй. Хөлийн хуванцар материалан хамгаалагчийн зузаан нь 2мм, шалтай харьцах доод ёроол хэсэг нь 4мм-ийн зузаатай резин хуванцарын нэгдэл бөгөөд энэ нь шал урахгүй зураас гаргахгүй, хагарахгүй давуу талтай. Хөлийн хамгаалагч нь зөвөөрлөх үед Техникийн шаардлагад бүрэн нийцсэн унахгүй бат бөх бэхлэгдсэн байх. Сандал нь тогтвортой бат бөх байна. Хөлийг дээш доош нь тохируулах боломжтой /Тохируулгын хоорондын хэмжээ 50-100мм, тохируулгын нүхний тоо 3-5, тохируулгын нүхний хэмжээ 10мм/, сандлын өндрийн тохируулагч нь салгаж буцааж хийхэд хялбар байх бөгөөд хийц нь энгийн, найдвартай түгжигддэг байх. Суудлын өндөр 380мм Суудлын үр ашигт гүн 360мм Суудлын өргөн 320мм Суудлаас дээш түшлэгийн дээд ирмэгийн өндөр 330мм Сандлын түшлэгийн өндөр 170мм</p>	240	
Нийт			312	

ХЯНАСАН: ХБТХОХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЭРДЭНЭБАТ

НБХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ДОРЖ

БОЛОВСРУУЛСАН: ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.БАТГЭРЭЛ

НБХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН- 60809 Ж.БАТБАЯР

